



“НОМУУН БЭХИ АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ” ХХК-ИЙН 2024 ОНЫ
12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТУХАЙ**

2025 оны 03 дугаар сарын 27



НОМУУН БЭХИ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо
Дамдинсүрэнгийн гудамж, Ю-Би тауэр, 1203а тоот
Утас: 77112488, 99096345, 94006880
И-мэйл: audit@nomuunbekhi.mn

“ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

2025 оны 03 сарын 27 өдөр ДГ- 19/25

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Аудиторын дүгнэлт

“ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон хугацааны тусдаа дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд “ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) -уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудаа энэ тайлангийн “Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулав.

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.



Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ. Компанийн удирдлага нь тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд тусдаа санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн тусдаа санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох тусдаа санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тусдаа санхүүгийн тайлангуудын (үүнд тодруулгууд багтана) ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар зөвлөмж өгч ажилладаг. Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох **"ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК**-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

"НОМУУН БЭХИ АУДИТ" ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид:

Гарын үсэг

Ц. Лхагвадулам

Ц. Лхагвадулам

Аудитор

Баталсан



Монгол Улс, Улаанбаатар хот

2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр

**"ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12-р сарын 31

(мянган төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2023	2024
1. ХӨРӨНГӨ		
1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,061,181	1,997,002
1.2 Зээл	44,630,219	77,372,555
1.3 Факторингийн тооцооны авлага		
1.4 Үүсмэл санхүүгийн хөрөнгө		
1.5 Хөрөнгө оруулалт		
1.6 Бусад санхүүгийн хөрөнгө	1,150,346	715,211
1.7 Санхүүгийн хөрөнгийн дүн	46,841,746	80,084,769
1.8 Татвар, НДШ-ийн авлага		3,509
1.9 Үндсэн хөрөнгө	683,218	852,007
1.10 Биет бус хөрөнгө	2,165	27
1.11 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.12 Бусад санхүүгийн бус хөрөнгө	112,215	253,690
1.13 Санхүүгийн бус хөрөнгийн дүн	797,599	1,109,233
1.14 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	47,639,345	81,194,002
2. Өр төлбөр		
2.1 Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		7,954,336
2.2 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		1,883,122
2.3 Бусад эх үүсвэр	7,121,043	15,236,836
2.4 Үүсмэл санхүүгийн өр төлбөр		
2.5 Бусад санхүүгийн өр төлбөр	4,915,054	6,013,331
2.6 Хоёрдогч өглөг		
2.7 Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)		
2.8 Санхүүгийн өр төлбөрийн дүн	12,036,097	31,087,624
2.9 Татвар, НДШ-ийн өр төлбөр		993,371
2.10 Нөөц /Болзошгүй өр төлбөр /		
2.11 Хойшлогдсон татварын өр төлбөр		
2.12 Бусад санхүүгийн бус өр төлбөр		1,130,274
2.13 Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	-	2,123,646
2.14 НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	12,036,097	33,211,270
2. Өмч		
3.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	11,177,360	12,167,360
3.2 Өмчийн бусад хэсэг	4,230	1,193
3.3 Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	24,421,657	35,814,179
3.4 НИЙТ ӨМЧИЙН ДҮН	35,603,248	47,982,732
3.5 НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	47,639,345	81,194,002

Хавсралт тодрууллагууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**"ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

2024 оны 12-р сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023	2024
1.Хүүгийн орлого		
1.1 Банканд байршуулсан хөрөнгийн		16,870
1.2 Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		
1.3 Зээлийн	13,544,679	21,863,097
1.4 Үнэт цаасны		
1.5 Бусад		355,690
1.6 (Хүүгийн орлогын буцаалт)		
1.7.Хүүгийн орлогын дүн	13,544,679	22,235,657
2.Хүүгийн зардал		
2.1 Итгэлцлийн үр шим		1,131,871
2.2 Зээлийн	164,182	164,848
2.3 Үнэт цаасны		1,871,216
2.4 Бусад		
2.5 (Хүүгийн зардлын буцаалт)		
2.6.Хүүгийн зардлын дүн	164,182	3,167,935
3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)	13,380,497	19,067,722
4.Эрсдэлийн сангийн зардал	1,528,860	1,650,996
5.Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)	11,851,637	17,416,725
6.Бусад орлого	500,435	1,436,740
6.1 Хүүгийн бус орлого	500,435	1,394,571
6.2 Бусад орлого, олз		42,169
7 Бусад зардал	2,877,009	4,614,288
7.1 Хүүгийн бус зардал	2,877,009	4,476,647
7.2 Бусад зардал, гарз		137,641
8.Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	9,475,063	14,239,178
9.Орлогын татварын зардал	871,474	2,632,539
10.Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	8,603,588	11,606,639
11.Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
12.Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	8,603,588	11,606,639
13.Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
14.Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн	8,603,588	11,606,639

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12-р сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	11,177,360	4,230	-	-	-	16,878,981	28,060,571
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл							
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал						8,642,677	8,642,677
Бусад дэлгэрэнгүй орлого							
Өмчид гарсан өөрчлөлт						(1,100,000)	(1,100,000)
Хуваарилсан ногдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							
2023 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	11,177,360	4,230				24,421,658	35,603,248
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							
Залруулсан үлдэгдэл							
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал						1,428,898	1,428,898
Бусад дэлгэрэнгүй орлого						25,850,555	37,032,145
Өмчид гарсан өөрчлөлт						11,606,639	11,606,639
Хуваарилсан ногдол ашиг							
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						(1,643,015)	986,962 (1,643,015)
2024 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	12,167,360	1,192	-	-	-	35,814,179	47,982,731

Хавсралт тодруулууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**"ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 12-р сарын 31

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2023	2024
1.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1 Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	13,356,121	69,422,117
1.2 Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	188,558	11,428,274
1.3 Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан		
1.4 Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	133,091	
1.5 Бусад	494,003	3,488,148
1.6 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	14,171,773	84,338,540
1.7 Олгосон зээл	164,182	79,685,605
1.8 Буцаан олгосон итгэлцэл, үр шим		13,106,996
1.9 Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн		
1.10 Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн		
1.11 Ажиллагсдад олгосон	1,110,486	1,530,227
1.12 Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,712,901	3,599,766
1.13 Ашиглалтын зардалд төлсөн	182,277	55,110
1.14 Бусад	10,677,013	
1.15 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	13,846,860	97,977,704
1.16 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	324,913	(13,639,165)
2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
2.2 Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан		
2.3 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан		
2.4 Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан		
2.5 Хүлээн авсан ногдол ашиг		
2.6 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого		
2.7 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.8 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.9 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.10 Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн		
2.11 Бусад		
2.12 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		
2.13 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3.САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1 Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан		13,250,000
3.2 Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан		
3.3 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		14,500,000
3.4 Бусад	(22,968)	
3.5 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	(22,968)	27,750,000
3.6 Банк, санхүүгийн байгууллага, төслийн зээлд төлсөн		11,550,000
3.7 Хоёрдогч өглөгт төлсөн		-
3.8 Төлсөн ногдол ашиг		1,625,014
3.9 Бусад		
3.10 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага		13,175,014
3.11 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		14,574,986
4. Валютын ханшийн зөрүү		
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	301,945	935,821
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	759,236	1,061,181
7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,061,181	1,997,002

Хавсралт тодруулууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

